



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/267

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.1.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдэд хүргэх номын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Төв номын сангийн фондод баяжилт хийхэд 5,000,000 (таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Уншигчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн номоор фонд баяжилт хийж, номын ашиглалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Төв номын сангийн дарга (Л.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

3.Дээрх зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0573